



**Миний суурь:
Зарчим, ур чадвар,
дадал хэвшил**

БИЕ ДААСАН БАЙДАЛ

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэн гаргав.

Юта муж, Солт Лэйк Сити

© 2014 by Intellectual Reserve, Inc.

Бүх эрх хамгаалагдсан. АНУ-д хэвлэв.

Англи эхийн зөвшөөрөл: 9/13. Орчуулгын зөвшөөрөл: 9/13.

My Foundation: Principles, Skills, Habits-ын орчуулга Mongolian 12374 363



МИНИЙ СУУРЬ

Эдгээр зарчим, ур чадвар, дадал хэвшлийг эзэмшин суралцаж, эдгээрийн дагуу амьдар. Эдгээр нь сүнслэг болон материаллаг байдлын хувьд бие даах чадвартай болоход хөтлөх болно.

Оршил.....	2
Эхлэх нь.....	3
1: Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүл	4
2: Цагаа ухаалаг ашигла	6
3: Дуулгавартай бай.....	8
4: Мөнгөө зөв зохицуул	10
5: Ажил: Хариуцлага хүлээдэг бай	12
6: Асуудлуудаа шийдвэрлэ	14
7: Нэгдмэл бай, хамтран ажилла	16
8: Харилцаа: Хүсэлт тавихын хамт сонс.....	18
9: Цөхрөлтгүй зүтгэ	20
10: Үнэнч шударга байдлаа харуул.....	22
11: Суралцаж, боловсролтой болохыг эрмэлз	24
12: Үүргээ гүйцэтгэж, ёслолуудыг хүлээн ав.....	26
Төгсгөлийн үйл ажиллагаа: Урагш тэмүүл, үйлчил	28



“Бие даах чадвар нь бидний ажлын үр жимс юм. . . . Энэхүү агуу ажилд бидний урагшлах эсэх нь тэнгэрлэгээр илчлэгдсэн халамжийн зарчмуудыг илүү гүнзгий ойлгож мөн илүү нарийн хэрэгжүүлж чадах эсэхээс шалтгаалдаг.”

ТОМАС С.МОНСОН,
“Guiding Principles of Personal and Family Welfare,” *Ensign*, 1986 оны 9-р сар, 3–5

ОРШИЛ

Хүндэт ах, эгч нар аа:

“Өөрийн гэгээнтнүүдийг хангах нь миний зорилго болой” (С ба Г 104:15) хэмээн Их Эзэн тунхагласан. Энэхүү илчлэлт нь бидэнд өөрсдийнхөө болон гэр бүлийнхээ гишүүдийн амьдралын хэрэгцээг хангах боломж олгохын тулд материаллаг адислалуудаар хангаж, бие даах чадвартай болох үүд хаалгыг нээж өгөх Их Эзэний амлалт юм.

Миний суурь хэмээх энэхүү товхимлыг Сүмийн гишүүдэд итгэл, боловсрол, шаргуу хөдөлмөрийн зарчмуудад болон Их Эзэнд итгэх итгэлд суралцан, амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах зорилгоор бэлтгэсэн болно. Эдгээр зарчмыг хүлээн зөвшөөрч, амьдралдаа хэрэгжүүлэх нь Их Эзэний амласан материаллаг адислалуудыг хүлээн авах боломжийг танд олгох болно.

Бид таныг эдгээр зарчмыг хичээнгүйлэн судалж, амьдралдаа хэрэгжүүлэн, гэр бүлийнхэндээ заахад урьж байна. Ингэснээр амьдрал тань адислагдах болно. Та бие даах илүү их чадвартай болохын тулд чухам юу хийх ёстойгоо мэдэж авах болно. Та илүү их найдвар, амар амгалан ба өсөлт хөгжилтөөр адислагдана.

Та Тэнгэр дэх Эцэгийнхээ хүүхэд гэдэгтэй итгэлтэй байгаарай. Тэрээр танд хайртай бөгөөд таныг хэзээ ч орхихгүй. Тэрээр таныг мэддэг бөгөөд бие даах чадвараа хөгжүүлснээр танд ирэх сүнслэг болон материаллаг адислалуудыг өгөхөд бэлэн байдаг.

Хүндэтгэсэн,

Тэргүүн Зөвлөл

ЭХЛЭХ НЬ

Тунгаан бод: Тэнгэрлэг Эцэг намайг яагаад бие даах чадвартай болоосой хэмээн хүсдэг вэ? Бид бие даах чадвартай болсноор Түүнтэй хэрхэн адилхан болдог вэ?

Унш: Бүлгийнхэнтэйгээ хамт Тэргүүн Зөвлөлийн захидал (2-р хуудсан дээрх) болон ерөнхийлөгч Монсоны хэлсэн үгийг (баруун гар талд байгаа) унш.

Ярилц: Эдгээр захиас дээр ямар ямар амлалт өгөгдсөн байна вэ? Таны үүрэг юу вэ?

Унш: Сургаал ба Гэрээ 29:34-ийг уншина уу (баруун гар талд байгаа).

Ярилц: Та нар Сургаал ба Гэрээ 29:34-өөс сургуульд сурах, ажилтай болох эсвэл бизнес эрхлэх талаар юу мэдэж авсан бэ? Энэ үнэнийг ойлгох нь яагаад чухал байдаг вэ?

Унш: *Миний суурь* товхимол нь бие даах чадвар хөгжүүлэх бүлгийн цугларалтуудын нэг чухал хэсэг юм. Эдгээр цугларалтад оролцдог, амлалтуудаа биелүүлдэг бүлгийн гишүүдэд ХҮГ Бизнес коллежээс гэрчилгээ хүлээн авах боломж бүрдэнэ. Гэрчилгээ хүлээн авахад тавигдах шаардлагуудыг харах бол 29-р хуудсыг гаргана уу.



Миний гэр бүл

Биднийг нэгтгэдэг түүхүүд



Миний суурийн 12-р зарчим дээр ариун сүмийн ёслолууд бие даах чадвартай холбоотой учир бид тэдгээрийн ач холбогдлын талаар ярилцах болно. Бид одооноос энэ хичээлд гэр бүлээрээ бэлтгэж эхэлж болно. *Миний гэр бүл:* Биднийг нэгтгэдэг түүхүүд товхимлыг ашиглан, гэр бүлийн түүхээ бичиж эхэлцгээе. Бид гэрээнүүддээ үнэнч байснаараа амьдралынхаа бүхий л тал дээр хүчирхэгжин, өвөг дээдэстээ адислалуудыг хүлээн авахад туслах болно.

“Бие даах чадвар нь . . . бидний сүнслэг болон материаллаг сайн сайханд нэн чухал юм. . . ‘Авралыг өөр ямар ч зарчмаар олж авах боломжгүй юм.’”

ТОМАС С.МОНСОН,
“Guiding Principles of Personal and Family Welfare,” *Ensign*, 1986 оны 9-р сар, 3

“Бүх зүйл миний хувьд сүнслэг юм гэдгийг би та нарт үнэнээр хэлнэ, мөн аль ч цаг үед би та нарт цаг зуурын хууль өгөөгүй бөлгөө.”

СУРГААЛ БА ГЭРЭЭ 29:34



Зохицуулагчид өгөх зөвлөгөө

Зааж буй
материалууддаа
итгэлтэй бай.
Тоймынхоо дагуу заа.
Цагаа үр дүнтэй
зохион байгуул.

7 ЕСҮС ХРИСТЭД ИТГЭХ ИТГЭЛЭЭ ХӨГЖҮҮЛ

ЕСҮС ХРИСТЭД ИТГЭХ ИТГЭЛЭЭ ХӨГЖҮҮЛ

Тунгаан бод: Есүс Христэд итгэх миний итгэл бие даах чадварт минь хэрхэн нөлөөлөх вэ?

Үз: "Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүл" (srs.lds.org. вэбсайтаас үзэх боломжтой. "Exercise Faith in Jesus Christ видео бичлэг байхгүй бол дараах хуудсыг уншина уу.)

Ярилц: Таныг илүү бие даасан байхад туслах Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлэхийн тулд та юу хийж чадах вэ?

Унш: Сургаал ба Гэрээ 104:15 (баруун гар талд байгаа).

Дасгал: Доорх түүхүүдээс нэгийг нь сонгож, өөрөө унш. Бие даах чадвараа хөгжүүлэхээр хичээхэд тань эдгээр судар та нарт ямар хамааралтай болох талаар бодож үзнэ үү. Бүлгийнхэнтэйгээ бодлоо хуваалц.

"Мөн өөрийн гэгээнтнүүдийг хангах нь миний зорилго болой."

СУРГААЛ БА ГЭРЭЭ 104:15

ИТГЭЛЭЭ ҮЙЛДЛЭЭР ХАРУУЛСНЫГ ТУСГАСАН СУДРУУД

Даниел залбирахаа болихгүй байсны учир тэрээр арслангийн нүхэнд хаягдсан ч, "Бурхан тэнгэр элчээ илгээж, арслангуудын амыг тагласан бөгөөд арслангууд түүнд хор учруулсангүй, . . . яагаад гэвэл тэр өөрийн Бурханд итгэсэн бөлгөө." **Даниел 6:22–23** (мөн 16–21-р шүлгүүдийг үзнэ үү)

"Итгэлтэй хүнд бүх юм боломжтой. . . . Хүү хүүр мэт болсонд. . . . Харин Есүс гараас нь барьж өндийлгөхөд, хүү босов." **Марк 9:23, 26–27** (мөн 17–22, 24–25-р шүлгүүдийг үзнэ үү)

"Тэдгээр нь өсөж үржихийн тулд төлөө гуй, талбай дахь сүргийнхээ." **Алма 34:25**

Их Эзэн Лихайд гэр бүлээ удирдах Лиахона өгсөн бөгөөд "Мөн энэ нь тэдний төлөө Бурханд итгэх итгэлийнх нь дагуу ажилладаг байжээ; . . . Тэд хойрго байж, мөн итгэлээ бас хичээнгүй байдлаа бодитой болгохоо мартсан [үед] мөн тэд аян замдаа урагшилсангүй." **Алма 37:40–41**

"Миний өргөөнд . . . бүхий л аравны нэгээ агуулахад авчир. Би та нарын төлөө тэнгэрийн цонхыг нээж, та нарын төлөө ивээлийг хальтал асгах эсэхийн талаар Намайг одоо үүгээр шалга." **Малахи 3:10**

Өлсгөлөнгийн үеэр, Елиа өөрт нь сүүлчийн хоолоо өгөхийг нэгэн бэлэвсэн эмэгтэйгээс хүсчээ. Елиа түүнд итгэлийнх нь учир Их Эзэн түүнийг хоол хүнсээр хангаж, түүний хоол хэзээ ч дуусахгүй хэмээн амлажээ. **Хаадын дээд 17**

"Хүн зөвхөн талхаар амьдардаггүй, харин хүн Эзэний амнаас гарах үг бүхнээр амьдардаг гэдгийг чамд ойлгуулахын тулд Тэрээр чамайг . . . [40 жилийн турш] маннагаар хооллож байсан." **Дэд хууль 8:3**

Дасгал: Та Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлж чадах хоёр тодорхой арга замыг бичнэ үү:

Амлалт өг: Энэ долоо хоногийн турш үлдсэн түүхүүд болон судруудыг тунгаан бодож, дараах үйлдлийг хийх амлалт өг. Даалгавар бүрийг хийж дуусгаад нүднүүдийг тэмдэглэ:

- Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлэх дасгалыг өдөр бүр хий.
- Энэ зарчмыг гэр бүлийнхэндээ заа.

ЕСҮС ХРИСТЭД ИТГЭХ ИТГЭЛЭЭ ХӨГЖҮҮЛ

Хэрэв та видео бичлэгийг үзэх боломжгүй бол энэ эхийг уншина уу.



АХЛАГЧ БЭДНАР: Үйлдэл хийх нь итгэлийг хөгжүүлдэг. Израилийн хүүхдүүд гэрээний авдрыг авч явдаг бөгөөд Иордан голын эрэгт ирдэг. Тэдэнд хуурай газраар гатлах болно хэмээх амлалт өгөгдсөн. Ус хэзээ хуваагдсан бэ? Тэдний хөл норох үед тэд гол руу алхан орж-үйлдэл хийдэг. Хүч дагалдан ирж-ус хуваагдсан.

Бид ихэнхдээ "Тийм ээ, би үүнийг төгс ойлгож байна, одоо үүнийг өөрийнхөө хийдэг зүйлс рүү хувиргах болно" хэмээн итгэдэг. Бидэнд хийж эхлэх зүйлс хангалттай байгааг би хэлмээр байна. Бидэнд зөв чиглэлийг дагах мэдрэмж байдаг. Итгэл бол зарчим бөгөөд энэ нь итгэл болоод хүч чадлын зарчим юм. Жинхэнэ итгэл нь Их Эзэн Есүс Христэд төвлөрдөг бөгөөд үргэлж үйлдэл рүү хөтөлдөг.

Дэвид А.Бэднар "What Must I Do?" [Leadership Pattern video, 2014]; "Seek Learning by Faith" [Сүмийн Боловсролын Системийн шашины багш нарт хандаж хэлсэн үгнээс, 2006 оны 2-р сарын 3] lds.org/media-library

"Египетээс гарсан нь 14-р бүлэг дээр Израилийн хүүхдүүдэд Мосе тэднийг Улаан тэнгис рүү авч яваа нь—авцалдаагүй санагдсан—учраас түүнийг [харааж байв] [яагаад гэвэл зугтах боломжгүй байв]. Тэд явсаар Фараоны цэрэгтэй хамт Улаан тэнгист тулж ирэхдээ өмнө нь хэзээ ч бий болж байгаагүй нэгэн нарийн замыг харна гэж төсөөлөөгүй байсан юм. Гэвч ийм зүйл болсон шүү дээ!"

НИЙЛ А.МАКСВЭЛЛ, "On the Straight and Narrow Way," *New Era*, 1971 оны 8-р сар, 42

2 ЦАГАА УХААЛАГ АШИГЛА

ЦАГАА УХААЛАГ АШИГЛА

Тунгаан бод: Цаг хугацаа яагаад Бурханы хамгийн агуу бэлгүүдийн нэг байдаг вэ?

Үз: "Цаг хугацаа бол бэлэг" ("The Gift of Time" видео бичлэг байхгүй бол дараах хуудсыг уншина уу.)

Ярилц: Та нар Бэнкоси эгчээс юу сурсан бэ?

Дасгал: Өдөр бүр цагаа сайн ашиглахын тулд таны хийж болох таван алхмыг энд оруулав. Бүгдийг нь унш. Бэнкоси эгч эдгээр зүйлийг хийдэг үү?

1

ХИЙХ ЗҮЙЛСИЙНХЭЭ ЖАГСААЛТЫГ ГАРГА

Өглөө бүр хийх ажлынхаа жагсаалтыг гарга. Үйлчлэх хүмүүсийнхээ нэрсийг нэмж бич.

2

ЗАЛБИР

Удирдамж хүсч залбир. Сонс. Хамгийн сайнаараа хийх амлалт өг.

3

ЧУХАЛ ЗҮЙЛСЭЭ ТОДОРХОЙЛ

Чухлаас нь эхлэн дугаарла. Хамгийн чухал ажлаа "1", дараагийнхыг нь "2" гэх мэтээр дугаарла.

4

ЗОРИЛГО ТАВЬЖ, ҮЙЛД

Сүнсийг сонс. Зорилго тавь. Шаргуу ажилла. Хамгийн чухал ажлаасаа эхлэн, бичсэн жагсаалтынхаа дагуу ажилла.

5

ТАЙЛАГНА

Орой бүр, Тэнгэрлэг Эцэгт хандан залбирч, тайлагна. Асуулт асуу. Сонс. Түүний хайрыг мэдэр. Наманчил.

Одоо эхэл. Энэ товхимлын тэмдэглэл бичих хэсэг дээр эсвэл тусдаа цаасан дээр бич. 1-р алхмыг хий: Маргааш хийх ажлуудаа жагсааж бич. Эдгээр нь өдөр тутам хийдэг энгийн ажил үүрэг гэхээсээ илүү, таны ажил, суралцах үйл явц, Сүм эсвэл гэр бүлийн үйлчлэл гэх мэт чухал ажил үүргүүд байвал сайн.

2, 3-р алхмыг хий.

Маргааш нь 4, 5-р алхмыг хий.

Амлалт өг: Долоо хоногийн турш дараах үйлдлүүдийг хийх амлалт өг. Даалгавар бүрийг дуусгаад, нүднүүдийг тэмдэглэ:

- Цагаа илүү ухаалаг ашиглахын тулд өдөр бүр эдгээр алхмыг давтан хий.
- Энэ зарчмыг гэр бүлийнхэндээ заа.
- Өмнөх суурь зарчмыг үргэлжлүүлэн давтан хий.

"Учир нь болгоогтун, энэ амьдрал бол хүмүүн Бурхантай уулзахаар бэлтгэх үе; тийм ээ, болгоогтун энэ амьдралын өдөр бол хүмүүн өөрсдийн хөдөлмөрийг гүйцэтгэх өдөр юм."

АЛМА 34:32

Зохицуулагчид өгөх зөвлөгөө

Бүлгийн гишүүдэд асуулт байвал хариултаа өөрсдөө олж мэдэхэд нь тусал.

ЦАГ ХУГАЦАА БОЛ БЭЛЭГ

Хэрэв та видео бичлэгийг үзэх боломжгүй бол дүрүүдийг сонгож, энэ эхийг уншина уу.

КОФИ: Сайн байна уу, Бэнкоси эгч ээ. Та сайн байна уу?

БЭНКОСИ ЭГЧ: Чи зүгээр үү, Кофи?

КОФИ: Өө, Бэнкоси эгч ээ. Би үнэхээр завгүй байна. Би ажиллаж, үйлчилж, гэр бүлдээ туслах хэрэгтэй байна . . . бас тэгээд хөл бөмбөг. Надад ямар ч цаг алга!

БЭНКОСИ ЭГЧ: Кофи, чамд хангалттай цаг байгаа.

КОФИ: Юу гэсэн үг вэ?

БЭНКОСИ ЭГЧ: Хүү минь, Бурхан чамд агуу бэлэг болох цаг хугацааг өгсөн. Бид үүнийг ашиглан, хамгийн чухал зүйлсийг хийх ёстой.

КОФИ: Гэхдээ, яаж, Бэнкоси эгч ээ? Та үргэлж маш их зүйлийг хийсээр ирсэн. Та гэр бүл болон бизнестээ амжилттай байдаг. Та үйлчлэл хийж, над шиг олон хүнийг адисалсан. Би таныг яаж энэ бүхнийг амжуулдгийг мэдэхгүй байна.

БЭНКОСИ ЭГЧ: Чи үнэхээр мэдэхийг хүсэж байна уу? Чи суугаад сонсвол би чамд нууцаа хэлье.

Би өглөө бүр нар мандахаас өмнө босдог. Би хувцсаа өмсөж, нүүр гараа угаадаг.

Би судраа уншиж, дараа нь тэр өдөр хийх зүйлсийнхээ жагсаалтыг гаргадаг.

Би үйлчилж чадах хэн нэгний талаар боддог. Би Бурханы хүслийг мэдэхээр залбирдаг. Тэгээд сонсдог.

Заримдаа хүмүүсийн нэр эсвэл царай төрх нь оюун санаанд минь ирдэг. Би тэдгээрийг жагсаалт дээрээ нэмж бичдэг.

КОФИ: Та хэнд үйлчлэх хэрэгтэйгээ үргэлж ийм арга замаар мэдэж авдаг уу?

БЭНКОСИ ЭГЧ: Тийм ээ, Кофи. Би хүч чадал болон удирдамжийн төлөө залбирдаг. Бурхан "[миний] үйлийг ариулахын тулд" би залбирдаг. Энэ талаар 2 Нифай 32 дээр байдаг.

Би Түүнд талархдаг. Би хамгийн сайнаараа хийх болно гэж Түүнд амладаг. Би Түүнээс өөрийнхөө чадахгүй зүйлсийг хийж өгөхийг гуйдаг.

Дараа нь би жагсаалтаа хардаг. Би хамгийн чухал зүйлээ "1", дараа нь "2" гэж дугаарладаг.

КОФИ: Та чухал зүйлсээ яаж мэддэг вэ?

БЭНКОСИ ЭГЧ: Би залбирч байхдаа сонсдог! Тэгээд ажиллахаар явдаг. Би нэгдүгээрт бичигдсэн ажлаа харж, үүнийг хамгийн түрүүнд хийхийг хичээдэг. Дараа нь хоёрдугаархыг гэх мэт.

Заримдаа төлөвлөгөө өөрчлөгддөг. Ариун Сүнс надад өөр зүйл хийх хэрэгтэй хэмээн ишвнэдэг. Энэ бол сайн зүйл юм.

Би маш шаргуу ажилладаг ч амар амгаланг мэдэрдэг. Бурхан надад тусална гэдгийг би мэддэг.

Ингэж би жагсаалт болон Сүнсний тусламжтайгаар хамгийн чухал зүйлсээ хийдэг юм, Кофи.

КОФИ: Энэ нь энгийн ч гэсэн заримдаа хэцүү юм шиг сонсогдож байна.

БЭНКОСИ ЭГЧ: Чиний зөв! Би эцэст нь унтахаар бэлдэж байхдаа залбирдаг. Би Тэнгэрлэг Эцэгт тайлагнадаг. Өдөр хэрхэн өнгөрснийг би Түүнд хэлдэг. Би асуултууд асуудаг. Би юуг илүү сайн хийж чадахаа асуугаад сонсдог. Би үргэлж Түүний хайрыг мэдэрдэг. Тэр бидний хийхээр хичээж буй зүйлсийг эрхэмлэн үнэлдгийг би мэддэг. Тэгээд би амар амгаланг мэдрээд унтдаг, Кофи.

КОФИ: Сайн байна, Бэнкоси эгчээ ээ. Би ийм амар амгалан олж авахыг хүсэж байна. Би цагаа ашиглахыг хүсэж байна. Би илүү сайн ажиллаж, үйлчлэхийг хүсэж байна.

БЭНКОСИ ЭГЧ: Чи чухал биш зүйлүүдээсээ татгалзаж, чухал зүйлдээ цагаа зарцуулах болно, Кофи. Зүрх сэтгэл чинь зөв байвал Бурхан чамтай хамт байх болно.

КОФИ: Баярлалаа.

БЭНКОСИ ЭГЧ: Одоо яв, хүү минь. Чамд хийх зүйл маш их байна!

"Цаг хугацаа бол дэлхий дээрх бүх хөрөнгө баялгийн эх ундарга юм. . . . Хэрэв цагийг зөв ашиглавал, энэ нь тав тух, давуу байдал болон сэтгэл ханамжийг тань нэмэгдүүлэх тэрхүү зүйлсийг авчрах болно. Үүнийг анхаарч, хойшид цагаа дэмий үрэн, гараа хумхин суухгүй байцгаая."

БРИГАМ ЯНГ, Discourses of Brigham Young, sel. John A. Widtsoe (1954), 214.

3 ДУУЛГАВАРТАЙ БАЙ

ДУУЛГАВАРТАЙ БАЙ

- Тунгаан бод:** Би илүү бие даах чадвартай болохын тулд ямар хуулинд дуулгавартай байх ёстой вэ?
- Үз:** “Дуулгавартай байдал адислалуудыг авчирдаг” (“Obedience Brings Blessings” видео бичлэг байхгүй бол дараах хуудсыг уншина уу.)
- Ярилц:** Бурханы хууль болон зарчмуудад дуулгавартай байх нь сүнслэг болон материаллаг адислалууд руу хөтөлдөг. Үүнийг батлах ямар туршлага танд тохиолдож байсан бэ?
- Унш:** Сургаал ба Гэрээ 130:20–21; Иосеф Смитийн хэлсэн үг (баруун гар талд байгаа).
- Дасгал:** Доорх хүснэгтийг харна уу. Тодорхой хуулиудад дуулгавартай байх нь хэрхэн тодорхой адислалууд руу удирдаж байгааг ажигла. Зарим жишээг оруулав.
- Одоо дараах зүйлсийг хийхэд хэдэн минут зарцуулна уу:
1. Та ажил хайж байхдаа, хувийн бизнес эрхэлж байхдаа эсвэл боловсролтой болохдоо олж авахыг хүсч байгаа тодорхой адислалуудаа бич. Баруун талын баганыг ашигла.
 2. Та эдгээр адислалыг хүлээн авахын тулд дуулгавартай дагаж чадах хуулиудаа зүүн талын баганыг ашиглан, жагсаан бич.

“Бүх адислал тулгуурлагдсан—нэгэн хууль бий. Мөн бид ямар ч адислалыг Бурханаас авлаа гэхэд, энэ нь тулгуурлагдсан тэрхүү хуульд дуулгавартай байснаар буюу.”

СУРГААЛ БА ГЭРЭЭ
130:20–21

“Би үүнийг дүрмээ болгосон юм: Их Эзэн зарлигласан л бол үүнийг хий.”

ИОСЕФ СМИТ, History of the Church, 2:170.

ДУУЛГАВАРТАЙ ДАГАХ

ХҮЛЭЭН АВАХ

Хууль, зарчмууд

Адислалууд

Мэргэн ухааны үг (С ба Г 89)

Илүү сайн эрүүл мэнд, агуу мэдлэг

Аравны нэг ба өргөлүүд (Малахи 3:10–12)

Материаллаг ба сүнслэг адислалууд, ажлын амжилт, хамгаалалт

Өдөр бүр цагтаа ажилдаа явах

Байнгын ажил болон хадгаламжтай болох боломж

Эрүүл хоол хүнс идэж, дасгал тогтмол хийх

Өвдөхгүй байж, ажлын өдрөө бага алдана

Дасгал: Та сонгосон хуулиндаа дуулгавартай байдлаа хөгжүүлж болох 2 юм уу 3 тодорхой арга замыг бичнэ үү:

Амлалт өг: Долоо хоногийн турш дараах үйлдлүүдийг хийх амлалт өг. Даалгавар бүрийг дуусгаад, нүднүүдийг тэмдэглэ:

- Өдөр бүр дуулгавартай байх дадлага хий.
- Энэ зарчмыг гэр бүлийнхэндээ заа.
- Өмнөх суурь зарчмаа үргэлжлүүлэн давтан хий.

ДУУЛГАВАРТАЙ БАЙДАЛ АДИСЛАЛУУДЫГ АВЧИРДАГ

Хэрэв видео бичлэгийг үзэх боломжгүй бол энэ эхийг уншина уу.



Энэ ямар гайхамшигтай амлалт вэ!
“[Бурханы] зарлигуудыг сахидаг тэрээр, үнэнд алдаршиж мөн бүх зүйлийг мэдэх хүртлээ үнэн ба гэрлийг хүлээж авдаг болой” [С ба Г 93:28]. . . .

Ах, эгч нар аа, дуулгавартай байдал нь энэ амьдралын хамгийн агуу шалгуур юм шүү. “Мөн Их Эзэн, тэдний Бурхан тэдэнд зарлиглах бүх зүйл юуг ч гэсэн тэд хийх нь үү гэдгийг харахын тулд үүгээр бид тэднийг нотлох болно” [Абрахам 3:25] хэмээн Их Эзэн хэлсэн байдаг.

Аврагч “Учир нь миний гараас адислалыг хүлээн авахыг хүсэх тэд бүгд тэрхүү адислалын тулд өгөгдсөн хуулийг, мөн үүний нөхцөлүүдийг, дэлхийн сууринаас өмнө үндэслэгдэн бий болсноор нь баримтлах ёстой” [С ба Г 132:5] хэмээн тунхагласан.

Аврагчийн үзүүлсэн дуулгавартай байдлын жишээнээс илүү гарах өөр жишээ байхгүй. Түүний талаар Паул:

“Тэр Хүү нь байсан хэрнээ зовсон зүйлсээсээ дуулгавартай байдал суралцсан;

“Тэр төгс болгогдсоноороо Өөрт нь дуулгавартай байдаг бүх хүнд мөнх авралын эх үндэс нь болсон” [Еврей 5:8–9] гэж хэлсэн байдаг.

Аврагч төгс амьдралаар амьдарч, ариун үүрэг зорилгодоо хүндэтгэлтэй ханддаг

байснаараа Бурханы жинхэнэ хайрыг харуулсан юм. Тэр ямар ч үед их зан гаргаагүй. Тэр хэзээ ч бардамнан онгирч байгаагүй. Тэр хэзээ ч урвагч болоогүй. Тэр ямагт төлөв даруу байсан. Тэр аливаад чин сэтгэлээсээ ханддаг байсан. Тэр байнга дуулгавартай байсан билээ. . . .

Тэрээр Гетсеманид амь тэмцэн зовж, “хөлс нь цусны дусал мэт газарт дуслан” [Лук 22:44], шаналах үедээ “Эцэг минь, хэрэв Та хүсэж байгаа бол, энэ аягыг Надаас зайлуулаач. Гэвч миний хүсэл бус харин Таны хүсэл биелэгдэг” [Лук 22:42] хэмээн хэлж, дуулгавартай Хүүгийн үлгэр жишээг харуулсан юм.

Тэрээр эртний төлөөлөгчдөдөө хэлж байсан “Чи Намайг дага” [Иохан 21:22] хэмээх үгсээ надад мөн танд ч адил хэлж байна. Дуулгавартай дагах хүсэл бидэнд байдаг уу?

Хайж буй мэдлэгээ, хүлээж буй хариултаа болон энэхүү адармаатай, хувирамтгай дэлхийн бэрхшээлүүдийг даван туулахад туслах хүч чадлыг бид Их Эзэний зарлигуудыг дуулгавартай дагаснаар л олж авч чадна. Их Эзэний үгсийг би дахин нэг эш татъя. Тэрээр: “[Бурханы] зарлигуудыг сахидаг тэрээр, үнэнд тэрээр алдаршиж мөн бүх зүйлийг мэдэх хүртлээ үнэн ба гэрлийг хүлээж авдаг болой” гэжээ [С ба Г 93:28].

Бид дуулгавартай хүмүүст гарцаагүй ирэх арвин баялаг адислалуудыг аваасай хэмээн би даруухнаар залбирч байна. Бидний Аврагч мөн Гэтэлгэгч Есүс Христийн нэрээр, амен.

(Томас С.Монсон, “Дуулгавартай байдал адислалуудыг авчирдаг, Ensign эсвэл 2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 103)

“Хэрэв бид дуулгавартай байдлаас илүүгээр тансаг байдал, хэрэгцээндээ илүү анхаарлаа хандуулбал Түүний бидэнд өгөхийг хүсдэг адислалуудыг алдах болно.”

СПЭНСЭР В.КИМБАЛЛ,
The Teachings of Spencer W. Kimball, ed. Edward L. Kimball (1982), 212

Зохицуулагчид өгөх зөвлөгөө

Тодорхой амлалт өгч, тэдгээрийг сахиж мөн гэр бүлийнхэндээ заахад урамшуул.

4 МӨНГӨӨ ЗӨВ ЗОХИЦУУЛ

МӨНГӨӨ ЗӨВ ЗОХИЦУУЛ

Тунгаан бод: Мөнгөө зөв зохицуулах нь яагаад хэцүү атлаа чухал байдаг вэ?

Үз: “Эхлээд хийх ёстой зүйлээ хийе!” (“First Things First!” видео бичлэгийг үзэх боломжгүй бол дараах хуудсыг уншина уу.)

Ярилц: Та энэ хүүхдүүдээс юу сурсан бэ? Бид яагаад мөнгөндөө тааруулж зарцуулах хэрэгтэй вэ? Бид яагаад мөнгөө хадгалах хэрэгтэй вэ?

Унш: *Бүх зүйл аюулгүйгээр хураагдсан* (*All Is Safely Gathered In*) хэлсэн үг; Сургаал ба Гэрээ 104:78 (баруун гар талд байгаа).

Дасгал: Та бусдад илүү сайн үйлчлэхийн тулд мөнгөө зөв зохицуулж болох дөрвөн алхмыг доор оруулав. Эдгээр алхмыг уншина уу. Үүнийг хэрхэн өөрсдийнхөө хэвшил болгож чадах талаар бүлгээрээ ярилц.

“Аравны нэг болон өргөлүүдээ төл, . . . өрнөөс зайлсхий, . . . төсвөө зохиож ашигла, . . . чухал биш зүйлүүдэд зарцуулж байгаа мөнгөө багасгах шийдвэр гарга . . . [мөн] төсвийнхөө хүрээнд багтааж амьдрахад өөрийгөө сахилгажуул.”

БҮХ ЗҮЙЛ АЮУЛГҮЙГЭЭР ХУРААГДСАН: ГЭР БҮЛИЙН ТӨСӨВ
(товхимол, 2007), 3

1

ШАРГУУ БӨГӨӨД УХААЛАГ АЖИЛЛА

Та өдөр бүр шаргуу ажилладгаа ажил олгогчдоо харуул. Өөрийнхөө үнэ цэнийг батлан харуул. Үнэнч бай.

2

АРАВНЫ НЭГ БА ӨРГӨЛҮҮДЭЭ ТӨЛ

Та өөрийн гэсэн мөнгөтэй болсон үедээ эхлээд аравны нэгээ төл. Тэгвэл Бурхан таныг адисалж чадна.

3

ОЛЖ БАЙГААГААСАА БАГЫГ ЗАРЦУУЛ

Төсвөө зохио. Орлого, зарлагаа тэмдэглэ. Өрнөөс зайлсхий. Илүү орлого ол. Олж байгаагаасаа багыг зарцуул.

4

ӨДӨР БҮР МӨНГӨ ХУРИМТЛУУЛ

Илүү амар тайван, илүү эрх чөлөөтэй болохын тулд өдөр бүр мөнгө хадгал.

Амлалт: Энэ долоо хоногийн турш дараах үйлдлийг хийх амлалт өг. Даалгавруудаа дуусгаад, нүднүүдийг тэмдэглэ:

- Өдөр бүр мөнгөө зөв зохицуулах дадлага хий.
- Энэ зарчмыг гэр бүлийнхэндээ заа.
- Өмнөх суурь зарчмуудаа үргэлжлүүлэн давтан хий.

“Мөн дахин, та нарын өрийн талаар үнэнээр би та нарт хэлж байна—болгоогтун, та нар бүх өрөө төлөх нь миний таалал билээ.”

**СУРГААЛ БА
ГЭРЭЭ 104:78**

Зохицуулагчид өгөх зөвлөгөө

Хэн нэгнийг эдгээр зарчим гэр бүлийг нь хэрхэн адисалсан талаар хуваалцахад урь.

ЭХЛЭЭД ХИЙХ ЁСТОЙ ЗҮЙЛЭЭ ХИЙЕ!

Видео бичлэг байхгүй бол дүрүүдийг сонгож, энэ эхийг уншина уу.



ТОХИРУУЛ: Эцэг эх болж жүжиглэж байгаа том хүний хувцас өмссөн эрэгтэй, эмэгтэй хүүхдүүд.

ХҮҮ: Хонгор минь, би ирлээ.

ОХИН: Гэртээ тавтай морил. Хонгор минь, чи ядарсан харагдаж байна.

ХҮҮ: Чи ч гэсэн. Чи их ажиллаа юу?

ОХИН: Тийм ээ, бид бүгдээрээ л ажиллах хэрэгтэй шүү дээ?

ХҮҮ: Би өнөөдөр 10-ыг олсон.

ОХИН: Өө, ямар сайхан адислал вэ. Эхлээд хийх ёстой зүйлээ хийе. Аравны нэгээ төлцгөө?

ХҮҮ: Бидэнд хангалттай мөнгө байхгүй шүү дээ?

ОХИН: Эндээс л итгэл бий болдог!

ХҮҮ: За, тэгээд яах вэ?

ОХИН: Тэгээд бид хоол хүнсээ, унааны тасалбараа худалдан авч, түрээсээ тө-

лөх хэрэгтэй. Тэгээд сандал авбал ямар вэ? . . .

ХҮҮ: Гэхдээ бид чадахгүй шүү дээ. Хараач? Бидэнд хангалттай мөнгө алга.

ОХИН: Бид мөнгө зээлж болно шүү дээ?

ХҮҮ: Өр аюултай гэж хүмүүс хэлдэг. Бид асуудалд орж болохгүй.

ОХИН: Тийм ээ. Чиний зөв. Тэгвэл үлдсэн мөнгөөрөө юу хийх вэ?

ХҮҮ: Мөнгөө хадгалцгаая! Чи юу болохыг хэзээ ч урьдаас мэдэхгүй шүү дээ.

ОХИН: Энэ чинь зөв санагдаж байна. Гэхдээ цагаа сайхан өнгөрүүлэхэд зарцуулах юу ч үлдсэнгүй.

ХҮҮ: Бид хоёр чинь нэг хүн шиг л байгаа шүү дээ! Би илүү их орлоготой болохыг хичээнэ ээ.

ОХИН: Би арай бага зарцуулж байхыг хичээе!

ХҮҮ: Ийм замаар бид аз жаргалтай бас бие даах чадвартай байж чадна!

ОХИН: Тийм ээ! Энэ нь тийм ч хэцүү байсангүй. Томчууд үүнийг яагаад ийм хэцүү болгодог юм бол?

ХҮҮ: Өө, Томчууд ийм л хүмүүс шүү дээ!

“Өнөө үед хүмүүс эрх ямба эдлэхээ л мэддэг юм шиг байдаг. . . . Бид хэт их өрөнд орж, хүнд дарамт үүрснээр бүх цаг, бүх эрч хүч, бүх арга замаа өрөө эргүүлэн төлөхөд зарцуулж, өөрсдийгөө хараат байдалд оруулдаг. . . . Бид зарлага ба хадгаламжийн төлөвлөгөө—төсөвтэй—болж хүсэл, хэрэгцээ хоёроо ялгаж сурах нь нэн чухал юм.”

РОБЭРТ Д.ХЭЙЛС, “Seek and Attain the Spiritual High Ground in Life” (Church Educational System fireside, 2009 оны 3-р сар, 6–7; speeches.byu.edu)

5 АЖИЛ: ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭДЭГ БАЙ

АЖИЛ: ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭДЭГ БАЙ

- Тунгаан бод:** Тэнгэрлэг Эцэг биднийг яагаад амьдралынхаа төлөө хариуцлага хүлээгээсэй хэмээн хүсдэг гэж та нар бодож байна вэ?
- Үз:** “Сэдриккийн аялал” (“Sedrick’s Journey” видео бичлэг байхгүй бол дараах хуудсыг уншина уу.)
- Ярилц:** Сэдрик хэрхэн сонгох эрхээ ашиглан, ирээдүйнхээ төлөө хариуцлага хүлээж байна вэ? Хэрэв Сэдрик өөртөө тохиолдсон сорилт бэрхшээлийн төлөө өөр хэн нэгнийг буруутгасан бол түүнд юу тохиолдох байсан бэ?
- Унш:** 2 Нифай 2:16, 26; Сургаал ба Гэрээ 42:42 (баруун гар талд байгаа).
- Дасгал:** Ойр байгаа бүлгийнхээ гишүүнд ханд. Бошиглогч Иосеф Смитийн хэлсэн дараах үгийг хамтдаа унш. Тэрээр өсөж том болсон үеийнхээ нөхцөл байдлыг дүрслэн бичжээ. Эдгээр асуултыг ярилц:
- Түүний материаллаг нөхцөл байдал ямар байсан бэ?
 - Та нар бошиглогчийн үгнээс бие даах чадварын талаар юу мэдэж авсан бэ?
 - “Урт удаан хөдөлмөр” гэдгийг бошиглогч ямар утгаар хэлсэн бэ?

“Миний эцгийн дэлхийн нөхцөл байдлууд туйлын хязгаарлагдмал байсан учраас, өдрийн хөлсний ажил олж хийх, эсвээс бидэнд азтай боломж олдсоноор бид өөрсдийнхөө гараар хөдөлмөрлөх зайлшгүй шаардлагатай байлаа. Заримдаа бид гэртээ, заримдаа гэрээсээ хол байдаг байв, мөн урт удаан хөдөлмөрийн улмаас бид ая тухтай байдалд байх боломжгүй байв.”

Иосеф Смит—Түүх 1:55

- Дасгал:** Бие даах чадвартай болох үүргээ хэрхэн илүү сайн ухамсарлаж болох талаараа бодож үз. Өөрийнхөө үйлдэл эсвэл хандлагадаа хийхийг хүсэж байгаа 2 юм уу 3 өөрчлөлтийг бич.
-
-

- Амлалт:** Энэ долоо хоногт дараах үйлдлүүдийг хийх амлалт өг. Даалгавар бүрийг дуусгаад, нүднүүдийг тэмдэглэ:
- Өдөр бүр хариуцлага хүлээх дадлага хий.
 - Энэ зарчмыг гэр бүлийнхэндээ заа.
 - Өмнөх суурь зарчмуудаа үргэлжлүүлэн давтан хий.

“Иймийн тул, Их Эзэн Бурхан хүнд өөрөө үйлдэх боломжийг өгчээ. . . . [мөн эрэгтэй, эмэгтэй хүмүүс] өөрсдийн төлөө үйлдэх мөн өөрсөд дээрээ үйлдүүлэхгүй байх чөлөөт болой.”

2 НИФАЙ 2:16, 26

“Чи залхуу байх ёсгүй; учир нь залхуу тэрээр хөдөлмөрлөгчийн талыг ч идэх, мөн өмсгөлүүдийг ч өмсөх ёсгүй бөлгөө.”

СУРГААЛ БА ГЭРЭЭ 42:42



СЭДРИКИЙН АЯЛАЛ

Хэрэв видео бичлэгийг үзэх боломжгүй бол энэ эхийг уншина уу.



СЭДРИК: Миний нэрийг Сэдрик Камбэсабве гэдэг. Би Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсад амьдардаг. Би ХҮГ Сүмийн гишүүн.

Би Кипусанга тосгоны салбарын номлогчоор үйлчилдэг. Би гадаадад номлолд үйлчлэхээр бэлтгэх хэрэгтэй байгаа. Номлолд явахын тулд 250 америк долларын үнэтэй паспорт хэрэгтэй.

Мөнгө олохын тулд аав бид хоёр гадил худалдаж авдаг. Тишабобо, Лусуку, Каманда гэх мэт зарим тосгонд гадил их ургадаг.

Тишабобо эндээс ойролцоогоор 9 бээрийн зайтай. Лусуку 18 бээр, Каманда бас 18 бээр зайтай. Бид тэнд очиж, гадил худалдаж аван, энд авчирч, зардаг.

Бид эдгээр тосгон руу дугуйгаар явдаг. Бид дөрвөөс зургаан багц гадил авч ирж чаддаг.

Хэрэв дугуй асуудалгүй, бас би хүч тэнхээтэй байвал дугуйгаар явахдаа нэг талдаа цаг гучин минут зарцуулдаг. Үд дунд нозоором халуун байдаг. Нартай халуун үед би удаан явдаг.

Хэрэв би өглөө их эрт сэрж чадвал өдөрт ойролцоогоор хоёр удаа явж чаддаг. Энэ нь паспорттай болоход минь түслэх сайн арга юм.

Би одоо бага багаар мөнгө олж байгаа болохоор сургууль болон номлолдоо зориулан мөнгө хуримтлуулж байгаа. 4 жил ажилласны эцэст одоо надад паспорт авах хангалттай мөнгөнөөс гадна 70 доллар хуримтлагдаад байна.

“Бурхан энэхүү мөнх бус байдлыг байнгын хичээл зүтгэл шаардахаар зохион байгуулсан юм. . . . Ажлаар бид амьдралыг тэтгэж мөн дүүргэдэг. . . . Ажил нь хүний мөн чанарыг сайжруулж, гоо сайхныг бүтээж, Бурханд болон бие биедээ үйлчлэх үйлчлэлийн маань гол зэвсэг болдог. Өргөл болгосон амьдрал үргэлж юмыг сайжруулах, . . . өөд нь татах болон . . . тэмүүлэх хүчээр дүүрэн байдаг.”

Д.ТОДД
КРИСТОФФЭРСОН,
“Өргөл болгосон амьдралын тухай бодол эргэцүүлэл,”
Ensign эсвэл 2010 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 17.

6 АСУУДЛУУДАА ШИЙДВЭРЛЭ

АСУУДЛУУДАА ШИЙДВЭРЛЭ

Тунгаан бод: Тэнгэрлэг Эцэг биднийг яагаад асуудал болон бэрхшээлүүдтэй тулгарахыг зөвшөөрдөг гэж та нар бодож байна вэ?

Үз: “Асуудлаа шийдвэрлэж, шийдвэр гарга” (“Solve Problems and Make Decisions” видео бичлэг байхгүй бол дараах хуудсыг уншина уу.)

Ярилц: Хонь гахайд асуудлаа шийдвэрлэхэд нь хэрхэн тусалсан бэ? (Тэр түүнд хэрхэн жинхэнэ асуудлаа олж тодорхойлох, сонголтуудыг олж харах, мөн шийдвэрээ гаргаж, үйлдэхэд нь тусалсан талаар бодож үз.)

Унш: Ифер 2, 3 (Зөвхөн баруун гар талд байгаа эшлэлүүдийг уншина уу).

Ярилц: Жаредын ах асуудлаа шийдвэрлэхийн тулд юу хийсэн бэ?

Дасгал: Бүх төрлийн асуудлаа залбирал болон итгэлээр шийдвэрлэхийн тулд таны хийж чадах 3 алхмыг доор оруулав. Тэдгээрийг бүлгийн нэг гишүүнтэй хамт уншиж, ярилц. Та нар бүгдээрээ өөрсдөдөө байгаа тодорхой асуудлуудыг олж тогтоогоод, дараах алхмуудыг хэрэгжүүлэх хэрэгтэй.

Шийдвэр гарга мөн үйлд

Удирдамж хүсч залбир. Шийдвэр гарга. Тэгээд итгэлээр үйлд. Сайн үр дүн гарсан уу? Хэрэв үгүй бол 1–3-р алхмыг дахин туршиж үз.

Бүү бууж өг!

ТОДОРХОЙЛ

Жинхэнэ асуудал нь юу вэ?



Сонголтуудыг судал

Ямар боломжтой шийдлүүд байна вэ?

Аль хамгийн сайн нь вэ?

Дасгал: Гэр бүлдээ тулгарч байгаа асуудлаа сонгож аваад, энд бичнэ үү:

Долоо хоногийн турш гэр бүлийнхэнтэйгээ хамт энэ асуудал дээрээ ажилла. Бууж өгч болохгүй гэдгээ сана! Асуудлыг шийдвэрлэж, өөрчлөлт хийхэд цаг хугацаа шаардагддаг.

Амлалт өг: Энэ долоо хоногт дараах үйлдлүүдийг хийх амлалт өг. Даалгавар бүрийг дуусгаад, нүднүүдийг тэмдэглэ:

- Дээр бичсэн асуудлуудаа шийдвэрлэх арга замуудыг давт.
- Энэ зарчмыг гэр бүлийнхэндээ заа.
- Өмнөх суурь зарчмуудыг үргэлжлүүлэн давтан хий.



“Жаредын ах Их Эзэнд хандан залбирч, хэлсэн нь: . . . би хөлгүүдийг бүтээлээ . . . [мөн] тэдэн дотор гэрэл үгүй болой. . . . Мөн Их Эзэн хэлсэн нь: . . . намайг хэрхэхийг та нар хүснэ вэ? [Жаредын ах] арван зургаан жижиг чулууг хайлуулан гаргаж авав. . . . Их Эзэнд хандан дахин ярьж, Ай Их Эзэн, та бүх хүчийг эзэмшдэг гэдгийг би мэднэ. . . . Тиймийн тул эдгээр чулуунд хуруугаараа хүрээч . . . тэдгээр нь харанхуйд гэрэлтэж болохын тулд.”

ИФЕР 2:18–19, 23; 3:1, 4

Зохицуулагчид өгөх зөвлөгөө

Ярилцлагуудыг эрч хүчтэй, идэвхтэй явуул. Хүн бүрийг оролцуул.

АСУУДЛУУДАА ШИЙДВЭРЛЭ, ШИЙДВЭР ГАРГА

Хэрэв энэ видео бичлэгийг үзэх боломжгүй бол дүрүүдийг сонгож, энэ эхийг уншина уу.



ГАХАЙ: Би өлсөж үхэх нь! Эзэн явчихсан. Түүний хүү залхуу, надад ямар ч хоол өгөхгүй юм. Би одоо яах вэ?

ХОНЬ: Гахай? Гахай! Чамд ямар асуудал байна вэ?

ГАХАЙ: Асуудал аа? Асуудал аа? Мэдээжийн асуудал биш байна гэж үү? Би өлсөж үхэх нь!

ХОНЬ: Хмм. Энэ чиний асуудал биш ээ.

ГАХАЙ: Аан? Энэ чинь юу гэсэн үг вэ? Би өлсөж байна! Тэр залхуу хүүхэд ажлаа хийхгүй байна шүү дээ.

ХОНЬ: Тийм ээ, гэхдээ энэ бол түүний асуудал. Хаанаас хоол олох вэ гэдэг нь чиний асуудал биз дээ?

ГАХАЙ: Хоол олох нь миний асуудал гэж үү?

ХОНЬ: Яг тийм. Чамд ямар ямар сонголт байна вэ?

ГАХАЙ: За, би эндээ үлдээд хүлээж байя!

ХОНЬ: Энэ бол нэг сонголт нь. Энэ нь хэр үр дүнтэй бол?

ГАХАЙ: Тийм ээ. . . . Хмм. . . . Хэрэв би эндээс гарвал хогийн цэгээс хоол олж магадгүй.

ХОНЬ: Энэ бол өөр нэг сонголт юм. Хүү хаалгыг чинь цоожлоогүй орхисныг би анзаарсан.

ГАХАЙ: Тийм ээ, гэхдээ би эндээс хэзээ ч гарч байгаагүй шүү дээ. Тэгээд ч хаанаас ч, ямар ч хоол олдохгүй биз дээ.

ХОНЬ: За, одоо шийдэж, ямар нэгэн зүйл хийх—үлдэх үү эсвэл явах уу гэдгээ шийдэх цаг болоод байна.

ГАХАЙ: За. Энэ одоо миний асуудал мөн үү?

ХОНЬ: Тийм ээ, мөн.

ГАХАЙ: Хогийн цэг миний хамгийн сайн сонголт болоод байна.

ХОНЬ: Хэрэв чи тэгж бодож байгаа бол.

ГАХАЙ: Тэгвэл би шийдээд, үйлдэх хэрэгтэй.

ХОНЬ: Би санал нэг байна.

ГАХАЙ: За. . . . За. . . . тэгвэл. . . . эндээс явъя. [Идэж эхлэв.] Хөөе, Хонь оо, энэ чинь гоёо хоол байна шүү.

ХОНЬ: Сайн байна, Гахай минь!

“Тухайн нөхцөл байдалд тохируулахад бүтээлч арга барил хэрэгтэй байдаг. Бидэнд ерөнхий удирдамж болон зарчмууд байдаг ч Их Эзэн бидэнд өөрсдийнхөө асуудлыг өөрсдөө шийдэхэд туслахыг хүсдэг. . . . Бид бодож, юуны төлөө хүн байгаагаа ойлгодог. Бидэнд хэрэгцээгээ тодорхойлох, төлөвлөх, зорилго тавих, асуудлуудаа шийдвэрлэх чадвар байдаг. . . . Дэндүү олон хүн амьдралд хэрэгждэггүй санаа, шинэ бодол болон аргуудтай зууралдсаар байдаг. Бүтээлч арга барил нь амьдралын хэрэгцээг хангах зам юм.”

РОБЭРТ Д.ХЭЙЛС, “Every Good Gift,” *New Era*, 1983 оны 8-р сар, 8–9

7 НЭГДМЭЛ БАЙ, ХАМТРАН АЖИЛЛА

НЭГДМЭЛ БАЙ, ХАМТРАН АЖИЛЛА

- Тунгаан бод:** “Нэгдмэл байх” гэдэг нь юу гэсэн үг вэ? Бие даах чадвартай болоход энэ нь ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?
- Үз:** “Их Эзэний арга замаар” (“In the Lord’s Way” видео бичлэг байхгүй бол дараах хуудсыг уншина уу.)
- Ярилц:** Бие биедээ үйлчилж, туслах талаар энэ захиас юу зааж байна вэ?
- Унш:** Мосе 7:18; Сургаал ба Гэрээ 104:15–17 (баруун гар талд байгаа).
- Дасгал:** Дараах үйл ажиллагааг хийнэ үү:
1. Өөртөө буй авьяас чадвар, холбоо барих хүмүүс эсвэл бусад эх сурвалжийн талаар дотроо бод. Бүлгийн бусад гишүүнийг илүү бие даах чадвартай болоход нь танд байгаа бэлгүүд хэрхэн тусалж чадах вэ? Санаануудаа бич:

 2. Бүлгээрээ жагсааж бичсэн авьяас чадвар, холбоо барих хүмүүс болон бусад эх сурвалжаа хуваалц. Танд тусалж болохуйц холбоо барих хүмүүс эсвэл эх сурвалжуудыг бичиж ав.

 3. Одоо Сүмийн бие даах чадвар хөгжүүлэх төвийн зөвлөхүүд, компьютерүүд гэх мэт эх сурвалжуудыг доор жагсаан бич. Эдгээр нь танд яагаад хэрэгтэй байдаг вэ?

 4. Өөртөө болон бусад хүнд бие даах чадвартай болоход тусалж чадах ямар ямар эх сурвалж танд байна вэ?

 5. Та бусдад бие даах чадвартай болоход нь хэрхэн туслах вэ?

 6. Та өөрөө бие даах чадвартай болохын тулд бусдын тусламжийг хэрхэн ашиглаж болох вэ?

“Мөн Их Эзэн өөрийн хүмүүсийг Сион хэмээн нэрлэв, учир нь тэд нэг зүрх сэтгэл мөн нэг оюунтай байлаа . . . мөн тэдний дунд ядуус байсангүй.”

МОСЕ 7:18

“Мөн өөрийн гэгээнтнүүдийг хангах нь миний зорилго болой, учир нь бүх зүйл минийх бөлгөө. Харин энэ нь миний өөрийн замаар хийгдэх ёстой нь шаардлагатай билээ; мөн болгоогтун энэ нь Их Эзэн, бибээр өөрийн гэгээнтнүүдийг хангаж ядуус өргөмжлөгдөж, үүнд баячууд дорд болгогдохоор миний тогтоосон зам юм. Учир нь дэлхий дүүрэн байна, мөн хангалттай бөгөөд нөөцлөхөөр буй.”

**СУРГААЛ БА ГЭРЭЭ
104:15–17**



Унш: Нэгдмэл байх дадлага хийхийн тулд, та нар дараах зүйлсийг хийж чадна:

- Нэгдмэл байдлаа нэмэгдүүлж мөн хамтдаа ажиллахад нь гэр бүлдээ тусал.
- Бие даах чадвартай тойргийнхоо гишүүдтэй ярилц. Ямар эх сурвалж эсвэл хүмүүс тэдэнд тусалсныг асуу. Танд зөвлөх боломжтой эсэхийг тэднээс асуу!
- Илүү бие даах чадвартай болоход тань туслах эх сурвалж бүхий орон нутагтаа байдаг гурван газарт оч. Тэдний үзүүлж чадах үйлчилгээнүүдийг бич. Тэднийг ашиглаж эхэл!

Амлалт өг: Энэ долоо хоногийн турш дараах үйлдлүүдийг хийх амлалт өг. Даалгавар бүрийг дуусгаад, нүднүүдийг тэмдэглэ:

- Бусад хүнтэй ажиллах дадлага хий (гэр бүлийн гишүүд, тойргийн гишүүд болон дээр жагсаан бичсэн орон нутгийнхаа эх сурвалжуудтай ажилла).
- Энэ зарчмыг гэр бүлийнхэндээ заа.
- Өмнөх суурь зарчмаа үргэлжлүүлэн давтан хий.

ИХ ЭЭЭНИЙ ЗАМААР

Хэрэв та нар видео бичлэгийг үзэх боломжгүй бол энэ эхийг уншина уу.



ЕРӨНХИЙЛӨГЧ АЙРИНГ: Сүмийн халамжийн хөтөлбөрийн суурь зарчмууд нь зөвхөн нэг цаг үед эсвэл нэг газар зориулагдаагүй юм. Тэдгээр нь бүх цаг үед, бүх газар зориулагдсан. . . .

Үүний хийгдэх арга зам нь тодорхой юм. Илүү ихийг хуримтлуулсан хүмүүс хэрэгцээтэй хүмүүст туслахаар өөрсдийгөө даруусгах ёстой.

Элбэг хангалуун байгаа хүмүүс нь өөрсдийн тав тух, цаг, авьяас болон нөөц боломжоосоо хэрэгцээтэй хүмүүсийн зовлонг нимгэлэхийн тулд сайн дураараа золиослох ёстой. Мөн энэ тусламж нь хүлээн авагчдын өөрсдөдөө [мөн дараа нь бусад хүмүүст] анхаарал тавих хүч чармайлт нь нэмэгдэх арга замаар өгөгдөх ёстой.

Ийнхүү, Их Эзэний арга замаар хийгдсэн үед ямар нэгэн гайхамшиг тохиох болно. Хүлээн авагч болон өгөгч аль алинд нь өгөгдөх болно.

(Хэнри Б.Айринг, address given at the dedication of the Sugarhouse Utah Welfare Services Center, June 2011, lds.org; words in brackets added by President Eyring in a March 2014 interview)

ЕРӨНХИЙЛӨГЧ УГДОРФ: Ах эгч нар аа, бүгдээрээ хэрэгцээг мэдэрч, Аврагчтай адил хүмүүст туслан, адисалж, сэтгэлийн дэм өгөх ёстой гэрээт хүмүүс билээ.

Бидний залбирлын хариу ихэнхдээ өвдөг сөгдөн сууж байх үед биш, харин Их Эзэнд болон эргэн тойрныхоо хүмүүст үйлчилж байхад ирдэг. Амь бие хайргүй үйлчилж, бүхнээ зориулах нь бидний сэтгэл санааг ариусган, сүнсний мэлмийг нээж, тэнгэрийн үүдийг дэлгэж өгдөг. Бид хэн нэгний залбирлын хариу болсноороо өөрсдийнхөө залбирлын хариуг авдаг.

(Дийтр Ф.Угдорф, "Дамаск орох зам дээр хүлээн сууна," Ensign эсвэл 2011 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 77–80.)

"Бид хамтран ажилласнаар, . . . юуг ч бүтээж чадна. Бид үүнийг хийснээр, ганцаараа зогсож буй нэг хүний сул талыг үгүй болгож, олуулаа хамтдаа үйлчилж байгаа хүмүүсийн хүч чадлаар орлуулах болно."

ТОМАС С.МОНСОН,
"Church Leaders Speak Out on Gospel Values," *Ensign*, 1999 оны 5-р сар, 118

8 ХАРИЛЦАА: ХҮСЭЛТ ТАВИХЫН ХАМТ СОНС

ХАРИЛЦ: ХҮСЭЛТ ТАВИХЫН ХАМТ СОНС

Тунгаан бод: Тэнгэрлэг Эцэг та нарын ажил, бизнес эсвэл боловсролын талаарх залбирлуудад хариулж байсан уу?

Үз: “Өргөх хүчийг бий болгох нь” (“Creating Lift” видео бичлэг байхгүй бол дараах хуудсыг уншина уу.)

Ярилц: Ерөнхийлөгч Угдорф бид дэлхийн зүйлсээс хэрхэн өөрсдийгөө өргөж чадна гэж хэлсэн бэ? Бидэнд залбирлынхаа хариуг ойлгодоггүй үе байдаг уу? Сонсох нь залбирлын чухал хэсэг мөн үү?

Унш: Сургаал ба Гэрээ 8:2; Ахлагч Нэлсоны хэлсэн үг (баруун гар талд байгаа).

Ярилц: Эдгээр асуултыг бүлгээрээ ярилц: Сонсох чадвар яагаад чухал байдаг вэ? Анхааралтай сонсох нь бидний ажилд хэрхэн тусалж чадах вэ?

Дасгал: Сонсох чадвараа хөгжүүлж сурахын тулд энэ үйл ажиллагааг хийнэ үү:

- Бүлгээрээ дараах алхмуудыг уншаад, тэдгээрийг товч ярилц.
- Бүлгийнхээ нэг юм уу хоёр гишүүнийг өөрсдөдөө байгаа бэрхшээл эсвэл асуултын талаар бусдадаа хэлэхийг хүс. Хүн бүр эдгээр алхмыг даган, сонсохыг хичээх хэрэгтэй.
- Хуваалцсан гишүүдээс бүлгийн гишүүд тэднийг үнэхээр сонсохыг хичээх үед тэдэнд ямар мэдрэмж төрсөн талаар хуваалцахыг хүс.

“Тийм ээ, болгоогтун, чамд ирж мөн зүрх сэтгэлд чинь орших Ариун Сүнсээр оюунд чинь мөн зүрх сэтгэлд чинь би чамд ярих болно.”

СУРГААЛ БА ГЭРЭЭ 8:2

“Та нар сонсож сурснаар мөн дараа нь хүүхдүүд, эцэг эх, хөрш, Сүмийн удирдагчдаа сонсож сурснаар та нарын бодгаль адислагдах болно. Эдгээр бүх зүйл дээрээс ирэх зөвлөгөөг сонсох бидний чадавхыг илүү их хөгжүүлэх болно.”

РАССЭЛЛ М.НЭЛСОН,
“Listen to Learn,”
Ensign, May 1991, 24

1 АНХААРЛАА ХАНДУУЛ

- Ярьж буй хүний үг болон үйлдлийг анхаар.
- Бүү тасалдуул.

4 АСУУ

- Асуу: “Би ойлгосон байна уу?”
- Хариултаа хүлээж, сонс.

2 ТАЛАРХ

- Ярьж буй хүн рүү хар.
- “Тийм” эсвэл “зөв” гэх мэт товчхон үгсийг ашигла.
- Ярьсан хүнд талархлаа илэрхийл.

3 ДАВТ


- Хэл: “Тэгвэл, таны хэлэх гэсэн санаа. . . .”
- Тэгээд сонссон зүйлээ давтаж хэл.

Амлалт өг: Энэ долоо хоногт дараах үйлдлүүдийг хийх амлалт өг. Даалгавар бүрийг дуусгаад, нүднүүдийг тэмдэглэ:

- Гэр бүлээрээ илүү сайн сонсож сурахын тулд эдгээр алхмыг давт:
 - Гэр бүлийнхээ нэг гишүүнээс өөртөө байгаа бэрхшээл эсвэл асуултын талаар хуваалцахыг хүс.
 - Энэхүү бэрхшээлийг нь сонсохдоо сонсох алхмуудыг давтан хий.
- Энэ зарчмыг гэр бүлийнхэндээ заа.
- Өмнөх суурь зарчмуудыг үргэлжлүүлэн давтан хий.

ӨРГӨХ ХҮЧИЙГ БИЙ БОЛГОХ НЬ

Хэрэв видео бичлэгийг үзэх боломжгүй бол энэ эхийг уншина уу.



Бидний өргөлтөд тусалдаг сайн мэдээний олон зарчим байдаг ч, би нэг л зарчим дээр тусгайлан анхаарал төвлөрүүлэхийг хүсч байна.

[Залбирал!]

Залбирал бол өргөлт бий болгодог сайн мэдээний зарчмуудын нэг юм. Залбирал нь биднийг дэлхийн [санаа зовоосон зүйлүүдээс], цөхрөл гутралын үүлс дундуур түүлэн, харанхуйгаас гэрэл гэгээтэй, цэлмэг тэнгэр рүү өргөн гаргах хүчтэй.

Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд бидэнд байдаг агуу адислал, онцгой хувь тавилан хийгээд боломжуудын нэг бол бид [залбирлаар дамжуулан] Түүнтэй харилцаж чаддаг явдал мөн. Бид амьдралынхаа туршилага, хүнд сорилт, адислалуудын тухай Түүнд ярьж, Ариун Сүнсийг сонсож мөн [ямар ч цагт, хаана ч] селестиел удирдамжийг нь хүлээн авч чадна.

(Дийтр Ф.Угдорф, “Залбирал ба хөх тэнгэр,” Ensign эсвэл Лиахона, 2009 оны 6-р сар, 5–6; хаалтанд байгаа үгсийг ерөнхийлөгч Угдорф 2014 оны 3-р сарын ярилцлага дээрээ нэмж хэлсэн)

ЕРӨНХИЙЛӨГЧ УГДОРФ: Нисэх онгоцыг газраас хөөргөхийн тулд та өргөлтийг бий болгох ёстой. Аеродинамикт нисэх онгоцны далавчин дээгүүр агаарын урсгал өнгөрөхөд далавчин доорх даралт далавчин дээрх даралтаас илүү гарсан тохиолдолд хөөрөлт бий болдог. Дээш өргөх хүч доош татах хүндийн хүчнээс давсан үед нисэх онгоц газраас дээш тасарч, нисдэг билээ.

Үүнтэй адилаар бид сүнсний амьдралдаа өргөлт бий болгож чадна. Биднийг тэнгэр өөд өргөх хүч нь уруу таталт, гай зовлонгоос илүү байгаа үед бид дээш өргөгдөж, Сүнсний орчинд дүүлэн нисч чадна.

“Идэх хоол, өмсөх хувцас, бие даан амьдрах чадвартай байхаас ирдэг сэтгэл ханамжийг гуйдаг, дэлхий даяарх хүүхдүүдийнхээ залбирлыг Тэнгэрлэг Эцэг сонсдог.”

ХЭНРИ Б.АЙРИНГ,
“Сайныг үйлдэх боломжууд,” Ensign эсвэл 2011 оны 4-р сар, 24

“Бид Тэнгэрлэг Эцэгээсээ тусламж хүсч, Түүний Хүү Есүс Христийн Цагаатгалаар ирэх хүчийг эрэлхийлэх ёстой. Материаллаг болон сүнсний зүйлсийн аль алинд бурханлаг тусламжийг олж авах нь өөрсдөдөө болон өрөөл бусдад ухаалаг, арвич хямгач, үлгэр жишээ үзүүлэгч байх боломжийг олгодог.”

РОБЭРТ Д.ХЭЙЛС,
“Материаллаг болон сүнсний зүйлст ухаалгаар арвилан хэмнэгч байх нь,” Ensign эсвэл 2009 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 6

9 ЦӨХРӨЛТГҮЙ ЗҮТГЭ

ЦӨХРӨЛТГҮЙ ЗҮТГЭ

- Тунгаан бод:** Бид ажлаа хийж дуустлаа хэрхэн үргэлжлүүлэн ажиллаж сурдаг вэ?
- Үз:** “Зөвхөн чулуу засагч” (“Only a Stonemason” видео бичлэг байхгүй бол дараах хуудсыг уншина уу.)
- Ярилц:** Хэцүү байсан ч бид хэрхэн үргэлжлүүлэн ажиллаж сурдаг вэ? Их Эзэнд итгэх итгэл нь бидний цөхрөлтгүй байх чадварт хэрхэн нөлөөлдөг вэ?
- Унш:** Ерөнхийлөгч Фаустын хэлсэн үг; Еврей 12:1; Сургаал ба Гэрээ 58:4 (баруун гар талд байгаа).
- Дасгал:** Цөхрөлтгүй байж мөн сорилтуудыг даван туулахын тулд энэ загварыг мэдэж авахад хамтдаа ажилла:
- Бүлгээрээ хамтдаа доорх загварт байгаа алхам бүрийг уншина уу.
 - Бүлгийнхээ хэн нэгэнд ханд. Ямар нэгэн хэцүү үүрэг эсвэл ажил тэдэнд тулгарч байгаа эсэхийг бие биенээсээ асуу.
 - Хэцүү үүрэг эсвэл ажлынхаа талаар ярилцан, доорх дөрвөн алхмыг гүйцээхэд бие биедээ тусал.
 - Цөхрөлтгүй байж—үүрэг даалгавар эсвэл ажлаа сайн хийж дуустлаа үргэлжлүүлэн хийнэ гэж бие биедээ амлалт өг.

“Цөхрөлтгүй байдал нь . . . бусад хүн “Үүнийг хийх боломжгүй” гэж хэлсэн ч бууж өгдөггүй хүмүүст харагддаг.

ЖЭЙМС И.ФАУСТ,
“Perseverance,” *Ensign*
эсвэл *Лиакона*, 2005
оны 4-р сар, 51

“Өмнөө тавигдсан уралдаанд тэвчээр-тэйгээр гүйцгээе.”

ЕВРЕЙ 12:1

“Их гай зовлонгийн дараа адислалууд ирдэг болой.”

СУРГААЛ БА ГЭРЭЭ 58:4

1	2	3	4
ЭРЭГ ХАНДЛАГАТАЙ БАЙ	ХАМТДАА АЖИЛЛАНА ГЭДГЭЭ САНА	АЙДСАА ИТГЭЛЭЭР ОРЛУУЛ	ТЭВЧЭЭРТЭЙ, ЗОРИГТОЙ УРАГШ ТЭМҮҮЛ
Адислалуудаа жагсаа.	Найзууд, үе тэнгийнхэн, бүлгийн гишүүд болон бусдаас тусламж хүс.	Бүү эргэлз. Их Эзэн бүх хүчийг эзэмшдгийг сана. Түүнийг дуудаж, Түүний хүслийг хүлээн ав.	Хэзээ ч, хэзээ ч, хэзээ ч бүү бууж өг; итгэлтэйгээр тэвч.

“Лемен, Лемүел хоёрыг урхидсан тэрхүү уруу таталтын золиос бүү бол. Тэд Лебенээс ялтсуудыг олж авах гайхалтай даалгаврыг хүлээж авахдаа хийхээр зарлигдуулсан тэр зүйлээ хэцүү гэж бувтнасан талаар цэдгүүд өгүүлдэг. Мөн тэд боломж болон шагналаа алдсан юм. Харин та нар өөрсдийнхөө хандлагыг тэдний дүү Нифайгийнхтай адил байлга: ‘Би явж бас Их Эзэний зарлиг болсон тэр зүйлүүдийг биелүүлэх болно’ (1 Нифай 3:5–7-г үзнэ үү).”

Томас С.Монсон, *Teachings of Thomas S. Monson* (2011), 54

Дасгал: Гэр бүлдээ тулгамдаж байгаа нэг сорилт бэрхшээлийг сонгож ав. Дээрх загварыг ашиглан, Их Эзэн арга замаар хангах болно гэдэгт итгэлтэй байж, та итгэлтэй урагшилж чадах хоёр эсвэл гурван арга замаа тодорхойл:

Амлалт өг: Долоо хоногийн турш дараах үйлдлүүдийг хийх амлалт өг. Даалгавар бүрийг дуусгаад, нүднүүдийг тэмдэглэ:

- Дээрх тодорхойлсон арга замаараа цөхрөлтгүй байх дадлага хий.
- Энэ зарчмыг гэр бүлийнхэндээ заа.
- Өмнөх суурь зарчмыг үргэлжлүүлэн давтан хий.

ЦОРЫН ГАНЦ ЧУЛУУ ЗАСАГЧ

Хэрэв та видео бичлэгийг үзэх боломжгүй бол энэ эхийг уншина уу.



АХЛАГЧ ХОЛЛАНД: Жонн Р.Моил бол Нэгдсэн Улсыг хиймэл хөлтэй түүлсан, Англиас ирсэн анхдагч юм. Тэрээр Солт Лэйкийн ариун сүмээс 22 бээрийн (35 километр) зайд Ютагийн Альпинд амьдардаг байв.

Бригам Янг Моил ахыг Солт Лэйкийн ариун сүмийн барилгын ажлын үеэр чулуун өрлөгийн ахлахаар дууджээ.

Моил ах даваа гараг бүрийн өглөө 8 цагт үргэлж ажил дээрээ байхын тулд шөнийн 2 цагаас 22 бээр газар алхдаг байв. Тэр ажлын долоо хоногоо баасан гаргийн 17 цагт дуусгаж, дараа нь гэр рүүгээ алхаж эхлэн шөнө дунд болохоос өмнөхөн гэртээ ирдэг байв. Тэрээр ариун сүмийн барилгын ажлын үеэр, бараг хорин жилийн турш энэ хуваариараа долоо хоног бүр ажилладаг байв.

Нэг удаа Моил ахыг долоо хоногийн сүүлчээр гэртээ байх үед нь үнээнүүдийнх

нь нэг нь саалгаж байхдаа утасхийн зугтаж, түүний хөлийг өшиглөн өвдөгнөөс доош ясыг нь бэртээжээ.

Тэд ферм дээрээ эмнэлгийн сайн тусламж авч чадаагүй аж. Тиймээс гэрийнхэн болон найзууд нь хаалгыг нугасаар нь салган авч, мэс заслын ширээ болгон орлуулж, үүн дээрээ түүнийг уяж бэхлэв. Тэд дараа нь ойролцоох ой модноос мөчрүүд тайрахдаа ашигладаг байсан дугуй хөрөөгөө аваад, өвдөгнөөс нь ердөө хэдхэн инч доогуур тайрсан гэнэ.

Эцэст нь Моил ах хөлөө эдгэж эхлэхэд мод авч, хиймэл хөл сийлэв. Тэр эхлээд гэртээ алхаж эхэлжээ. Дараа нь хашааныхаа эргэн тойронд алхдаг болов. Эцэст нь тэрээр хиймэл хөлөөрөө азаа түршсэн юм.

Тэр зогсож байхдаа өвдөлт мэдэрсэн ч модон хөлөө бэхэлж, Солт Лэйкийн ариун сүм хүртэл 22 бээр алхаж, барилгын шат өөд авирч, “Их Эзэнд ариуныг” хэмээх тунхгийг гартаа цүүц барин сийлжээ.

(Мөн Жэффри Р.Холланд, “As Doves to Our Windows,” Ensign, 2000 оны 5-р сар, 76–77-г үзнэ үү.)

“Бидний үүрэг бол энгийн дундаж байдлаас чадвартай болж, бүтэлгүйтлээс амжилт өөд өгсөх явдал юм. Бидний үүрэг даалгавар бол өөрсдийнхөө байж болох хамгийн сайн түвшинд авчрах явдал юм. Бурханы хамгийн агуу бэлгүүдийн нэг бол сүүлчийн удаа байсан ч бүтэлгүйтэхгүйн тулд дахин оролдож үзэх баяр баясгалан юм.”

ТОМАС С.МОНСОН “The Will Within,” Ensign, 1987 оны 5-р сар, 68

10 ҮНЭНЧ ШУДАРГА БАЙДЛАА ХАРУУЛ

ҮНЭНЧ ШУДАРГА БАЙДЛАА ХАРУУЛ

Тунгаан бод: Их Эзэн яагаад “зүрх сэтгэлдээ үнэнч шударга” хүмүүсийг хайрладаг гэж та нар боддог вэ? (Сургаал ба Гэрээ 124:15-ыг үзнэ үү.)

Үз: “Амиа сольж авахын тулд хүн юугаа өгөх юм бэ?” (“What Shall a Man Give in Exchange for His Soul?” видео бичлэг байхгүй бол дараах хуудсыг уншина уу.)

Ярилц: Үнэнч шударга байна гэдэг нь юу гэсэн утгатай вэ? Хүмүүс энэ амьдрал дахь эд зүйлсийг сүнсээрээ сольж авдаг ямар ямар арга зам байдаг вэ?

Унш: Итгэлийн Тунхаг 1:13; Мозая 4:28; Иов 27:5 (баруун гар талд байгаа).

Дасгал: Та нар дараах хэсэгт өөрсдийгөө дүгнэнэ үү.

Та үүнийг ямар арга замаар хийдгээ харуулахын тулд хэсэг бүрийн өмнө тоо тавь. 1 = хэзээ ч үгүй, 2 = заримдаа, 3 = ихэвчлэн, 4 = бараг үргэлж, 5 = үргэлж

- ___1. Би бүх амлалт, үүрэг болон гэрээнүүдээ сахидаг.
- ___2. Би хэлж мөн бичиж байгаа бүх зүйлдээ бүрэн дүүрэн үнэнч ханддаг.
- ___3. Би аливаа зүйлийг харагдаж байгаагаас нь илүү сайн болгохоор хэтрүүлж ярьдаггүй.
- ___4. Би зээлсэн бүхнээ эргүүлж өгдөг бөгөөд надад хамаагүй зүйлийг авдаггүй.
- ___5. Би ханьдаа үг болон үйлдлээрээ бүрэн дүүрэн үнэнч байдаг.
- ___6. Би хэзээ ч баригдахгүй гэдгийг мэдэж байсан ч хэзээ ч хуурч мэхэлдэггүй.
- ___7. Би ямар нэгэн зүйлийг минийх биш гэдгийг мэдмэгцээ эзэнд нь эргүүлж өгдөг.
- ___8. Би Сүмээс зээлсэн ТБС-ийн зээл гэх мэт зээлүүдээ үргэлж буцааж төлдөг.

Амлалт өг: Долоо хоногийн турш дараах үйлдлүүдийг хийх амлалт өг. Даалгавар бүрийг дуусгаад, нүднүүдийг тэмдэглэ:

- Өдөр бүр үнэнч шударга байдлаа харуулах дадлага хий.
- Энэ зарчмыг гэр бүлийнхэндээ заа.
- Өмнөх суурь зарчмуудыг үргэлжлүүлэн давтан хий.

“Шударга, үнэнч, . . . явдалд бид итгэдэг.”

ИТГЭЛИЙН ТУНХАГ 1:13

“Мөн та нарын дунд хөршөөсөө зээлсэн хэн боловч зээлсэн тэр зүйлээ тохирсны дагуу эргүүлж өгөх ёстой, эсвээс та нүгэл үйлдэх болно; мөн магад та өөрийн хөршийг түүнчлэн нүгэл үйлдэхэд хүргэх вий гэдгийг та нар санаасай хэмээнэ би.”

МОЗАЯ 4:28

“Үхэн үхтлээ би өөрийн үнэнч байдлаа өөрөөсөө холдуулахгүй.”

ИОВ 27:5

Зохицуулагчид өгөх зөвлөгөө

Хүн бүрд зөвхөн ярихаасаа илүү үйлдэлдээ анхаарахад нь тусал.

АМИА СОЛЬЖ АВАХЫН ТУЛД ХҮН ЮУГАА ӨГӨХ ЮМ БЭ?

Хэрэв та видео бичлэгийг үзэх боломжгүй бол энэ эхийг уншина уу.



АХЛАГЧ РОБЭРТ С.ГЭЙ: Аврагч Өөрийн шавь нараас “Амиа сольж авахын тулд хүн юугаа өгөх юм бэ?” хэмээн асуусан байдаг.

Энэ асуултыг аав маань олон жилийн өмнө надад анхааралтайгаар тунгаан бодохыг засан юм. Намайг бага байхад аав ээж маань надад гэрийн ажлыг даалгаж, хариуд нь надад багахан хэмжээний мөнгө өгдөг байлаа. Би долоо хоногт 50 центээс арай илүү их мөнгө авдаг байсан бөгөөд тэрхүү мөнгөөрөө ихэнхдээ кино театрт кино үздэг байсан юм. Тэр үед 11 настай хүүхдийн тасалбар 25 цент байсан болохоор надад 25 цент үлддэг байлаа. Би үлдсэн мөнгөөрөө нэг ширхэг нь 5 центийн үнэтэй 5 чихрийн цуглуулга авдаг байсан. 5 чихрийн цуглуулгатай кино! Би үүнээс илүү сайхан байж чадна гэж үү.

Намайг 12 нас хүртэл бүх зүйл ийм сайхан хэвээрээ байлаа. Нэгэн өдөр би киноны тасалбар авахаар зогсож байхдаа 12 настай хүүхдийн тасалбар 35 цент болохыг анзаарлаа. Энэ нь хоёр чихрийн цуглуулганы мөнгө хасагдана гэсэн үг байлаа. Би энэхүү золиослолыг хийхэд бэлэн биш байсан учраас өөртөө “Чи долоо хоногийн өмнөх шигээ л харагдана шүү дээ” гэж өөртөө шалтаг олсон юм. Би урагшилж, 25 центийн тасалбар өгөхийг хүслээ. Тасалбар зардаг хүн анзаарсангүй, би ч гурав биш харин урьдын адил таван чихрийн цуглуулга худалдан авлаа.

Өөрийнхөө хийсэн зүйлд баяртай байсан болохоор би аавдаа өөрийнхөө том амжилтыг хэлэхээр гэр рүүгээ яарч билээ. Намайг бүх зүйлийн талаар нэг бүрчлэн хэлэхэд аав маань юу ч хэлээгүй юм. Намайг ярьж дууссаны дараа тэр над руу хараад “Хүү минь, чи өөрийнхөө амийг таван центийн зоосоор солих байсан уу?” гэж асуусан юм. Түүний үгс миний зүрх сэтгэлд дэндүү хүчтэй нөлөөлж, энэ нь хэзээ ч мартаггүй хичээл болсон юм.

Роберт С.Гэй, “Амиа сольж авахын тулд хүн юугаа өгөх юм бэ?” Ensign эсвэл 2012 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 42.)

“Үнэнч шударга зан нь шууд үр дүнгээс үл хамааран үргэлж зөв болон сайн зүйлийг хийх гэсэн үг юм. Энэ нь зөвхөн бид үйлдлүүддээ төдийгүй хамгийн чухал нь бодол, зүрх сэтгэлдээ чин сэтгэлээсээ зөв шударга байна гэсэн утгатай юм. . . . Бага зэрэг худал хэлэх, бага зэрэг хуурч мэхлэх эсвэл бага зэрэг шударга бус зүйлийг давуу тал болгон ашиглахыг Их Эзэн хүлээн зөвшөөрдөггүй. . . . Үнэнч шударга байдлын бүрэн төгс шагнал нь биднийг хийж буй бүх зүйлд удирдан чиглүүлэх Ариун Сүнс байнга хамт байх явдал юм.”

ЖОЗЕФ Б.ВӨРТЛИН,
“PERSONAL INTEGRITY,”
Ensign, 1990 оны
5-р сар, 30–33.

11 СУРАЛЦАЖ, БОЛОВСРОЛТОЙ БОЛОХЫГ ЭРМЭЛЗ

СУРАЛЦАЖ, БОЛОВСРОЛТОЙ БОЛОХЫГ ЭРМЭЛЗ

- Тунгаан бод:** Боловсрол бол боломжинд хүргэх түлхүүр хэмээн бошиглогчид хэлсэн байдаг. Үүнийг үнэн гэдэг ямар нотолгоог та нар харсан бэ?
- Үз:** “Бурханы алдар суу бол оюун ухаан юм” (“The Glory of God Is Intelligence” видео бичлэг байхгүй бол дараах хуудсыг уншина уу.)
- Ярилц:** Александр яагаад амьдралынхаа турш суралцах нь чухал гэдэгт итгэдэг вэ? Эмэльд боловсролын талаар болон шаргуу суралцах талаар юу гэж боддог вэ? ТБС-ийн зээл түүнд хэрхэн тусалсан бэ? Энэ нь өр тавих сайн шалтгаан мөн байсан уу?
- Унш:** Сургаал ба Гэрээ 88:118–119; *Гарын авлага 2,6.1.1* (баруун гар талд байгаа).
- Дасгал:** Бид амьдралынхаа турш үргэлжлүүлэн суралцаж чадна. Доорх нүдэнд эдгээр суралцах эх сурвалжаас саяхан сурсан нэг зүйлээ бич.

СУРАЛЦАХ ЭХ СУРВАЛЖУУД	ЭДГЭЭР ЭХ СУРВАЛЖААС САЯХАН СУРСАН ЗҮЙЛС
Миний эргэн тойрны хүмүүс, миний удирдагчид	
Амьдралын туршлагауд	
Ном, хэвлэл мэдээллийн хэрэгсэл	
Ангийнхан/багш	
Судрууд, ариун сүм, Ариун Сүнс	

- Ярилц:** Та нар хэрхэн өдөр бүр үргэлжлүүлэн суралцаж, өсөж хөгжиж чадах вэ?

“Мөн бүгдээр итгэлгүй байгаа учраас, та нар хичээнгүйлэн эрэлхийлж мөн мэргэн ухааны үгсийг бие биендээ заагтун; тийм ээ, мэргэн ухааны үгсийг шилдэг номнуудаас эрэлхийлэгтүн та нар; бүр судлахаар мөн тэрчлэн итгэлээр, суралцахыг эрэлхийлэгтүн. . . . Суралцахын өргөөг . . . байгуулагтун.”

СУРГААЛ БА ГЭРЭЭ 88:118–119

“[Сүмийн гишүүд] унших, бичих, математикийн үндсэн үйлдлүүд хийх чадвараа дээшлүүлэх хэрэгтэй. Тэд боломжийнхоо хэрээр боловсрол түүний дотор ерөнхий болон тусгай мэргэжлийн боловсрол эзэмших хэрэгтэй.”

ГАРЫН АВЛАГА 2, 6.1.1



Амлалт өг: Долоо хоногийн турш дараах үйлдлүүдийг хийх амлалт өг. Даалгавар бүрийг дуусгаад, нүднүүдийг тэмдэглэ:

- Сурах боломжуудыг эрэлхийлж мөн сурсан зүйлсээ бичиж ав.
- Амьдралынхаа турш суралцаж болох өөр өөр эх сурвалжийн талаар гэр бүлийнхэндээ заа. Гэр бүлийнхэн тань—насанд хүрсэн болон хүүхдүүд аль алинд нь илүү боловсрол эзэмших арга зам байгаа эсэхийг бодож үз.
- Өмнөх суурь зарчмуудаар үргэлжлүүлэн дадлага хий.

БУРХАНЫ АЛДАР СУУ БОЛ ОЮУН УХААН ЮМ

Видео бичлэг байхгүй бол дүрүүдийг сонгож, энэ эхийг уншина уу.



ӨГҮҮЛЭГЧ: Александр бол бүхий л амьдралаа суралцах болон заахад зориулж байгаа Перугаас ирсэн залуу юм. Тэрээр дараах зүйлийг хуваалцсан ажээ:

АЛЕКСАНДР: Намайг бага байхад аав маань бидэнд суралцах, боловсролын үнэ цэнийн тухай заасан юм.

Энэ амьдралд бидэнд өсөж хөгжиж, амжилтад хүрэхийн тулд хийж чадах хоёр зүйл байдаг. Нэгдүгээрт, итгэлтэй байж, эцсээ хүртэл тэвчих. Хоёрдугаарт, судлах замаар суралцах.

Би боловсрол бол амьдралынхаа зорилгуудыг гүйцэлдүүлэх ёстой материаллаг гол арга хэрэгсэл гэдгийг амьдралынхаа туршид мэдэж авсан юм.

Би сайн мэдээний өчүүхэн жаахан мэдлэгтэй ч, зөв зүйлсийг хийх мөн суралцах агуу их хүслээр номлолдоо явж байсан.

Би хэдийгээр анги танхимд суугаагүй ч миний номлол бол миний амьдрал дахь хамгийн агуу суралцах цаг хугацаа байсан гэдэгт итгэдэг.

Би хаана ч байсан, гэр, ажил, сүм, их сургууль дээрээ эсвэл бүр автобусанд явж байсан ч суралцах боломжуудыг ашигладаг. Би үргэлж сурах боломжийг эрэлхийлж байдаг.

Ариун сүм бол миний амьдралын хамгийн чухал газар бөгөөд дэлхий дээрх хамгийн сайн сургууль юм.

ӨГҮҮЛЭГЧ: Эмальда Өмнөд Африкт амьдардаг бөгөөд Тасралтгүй Боловсролын Сангийн зээлээр дамжуулан хүсэл мөрөөдлөө ойлгосон Сүмийн хөрвөгч юм. Тэрээр гэрчлэлээ хуваалцсан:

ЭМАЛЬДА: Шилдэг оюутан байх нь зөвхөн өөртөө үүрэг хүлээгээд зогсохгүй бас Сүмд үүрэг хүлээж байгаа хэрэг юм! Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд нэгдэх нь намайг агуу сүнслэг байдалд аваачих болно гэдгийг би мэдэж байсан ч энэ нь академик боловсролын үүд хаалгыг нээн гэж хэзээ ч төсөөлж байгаагүй юм. . . .

Сайн мэдээнээс суралцах нь үнэн хэрэгтэй намайг сэрээх дуудлага байсан юм. Энэ нь хүн өөрийнхөө хувь заяанд үүрэг хүлээдэг гэдгийг надад ойлгуулсан юм. . . . Бидний одоогийн нөхцөл байдал болон бидний юу мэдэрч байгаагаас үл хамааран Тэнгэрлэг Эцэгт бидэнд зориулсан сайн төлөвлөгөө байдаг гэдэгт би эргэлздэггүй.

“Бид бизнес, шинжлэх ухаан, засгийн газар, анагаах ухаан, боловсрол болон бүхий л үнэ цэнэтэй, бүтээлч мэргэжлийн салбарт байр суурь эзлэх үүрэг, хариуцлагатай билээ. Бид бүх хүн төрөлхтний адислалуудын төлөө дэлхийн ажил мэргэжилд гаршихын тулд гар болон оюун ухаанаа хөгжүүлэх үүрэгтэй билээ.”

ГОРДОН Б.ХИНКЛИ, “A City upon a Hill,” Ensign, 1990 оны 7-р сар, 5

12 ҮҮРГЭЭ ГҮЙЦЭТГЭЖ, ЁСЛОЛУУДЫГ ХҮЛЭЭН АВ

ҮҮРГЭЭ ГҮЙЦЭТГЭЖ, ЁСЛОЛУУДЫГ ХҮЛЭЭН АВ

- Тунгаан бод:** Биднийг хамгийн чухал зүйлсээ хийхэд юу саад болдог вэ?
- Үз:** “Хамгийн чухал зүйлсээ хийх нь” (“Doing What Matters Most” видео бичлэг байхгүй бол дараах хуудсыг уншина уу.)
- Ярилц:** Хүмүүс ямар ямар чухал биш зүйлийг хийж цагаа дэмий үрдэг вэ? Сүмийн гишүүд маш ядуу байсан ч Их Эзэн ариун сүм барихыг Иосеф Смитэд зарлигласан. Яагаад?
- Унш:** Сургаал ба Гэрээ 84:20; 136:4; 1 Нифай 18:2–3 (баруун гар талд байгаа).
- Унш:** “Хөрсний менежментийн хууль” (дараагийн хуудсанд байгаа.)
- Ярилц:** Их Эзэн ариун сүм дотор ахлагч Видцөүд юу илчилсэн бэ? Их Эзэн уулан дээр Нифайд юу илчилсэн бэ?
- Бид бие даах чадвартай болохыг эрэлхийлэх үедээ ариун сүмд орохуйц зохистой байх нь яагаад чухал вэ?
- Хамтрагчийнхаа хамт доорх судрыг унш. Бид ариун сүмд шүтэн биширснээр амьдралдаа хэрэгцээтэй бүхий л зүйлсийг хүлээн авахад бэлтгэгддэг гэдэг нь та нарын хувьд юу гэсэн үг вэ? Энэ нь та нарын амьдралд болон бие даах чадвартай болох зорилгод тань ямар ашиг тустай болох талаар ярилц.

“Мөн ариун Эцэг минь, энэ өргөөнд шүтэн бишрэх тэд бүгд . . . мөн хэрэгтэй юм болгоныг олж авахад бэлтгэгдэж болохын тулд буюу.”

Сургаал ба Гэрээ 109:14–15

- Амлалт өг:** Долоо хоногийн турш дараах үйлдлүүдийг хийх амлалт өг. Даалгавруудыг хийж дуусгаад, нүднүүдийг тэмдэглэ:
- Өдөр бүр, ариун сүмд орохоор зохистой байх дадлага хий.
 - Энэ зарчмыг гэр бүлийнхэндээ заа. Ариун сүмд орох нь тэдэнд сүнслэг болон материаллаг байдлын хувьд хэрхэн амжилттай байхад нь туслах талаар заа, мөн ариун сүмийн ёслолуудаар дамжуулан олж авах боломжтой Их Эзэний хүчийг хүлээн авахын тулд юу хийх ёстойг тэдэнтэй ярилц.
 - Өмнөх суурь зарчмуудыг үргэлжлүүлэн дадлага хий.

“Тиймийн тул, үүний ёслолуудад бурханлиг чанарын хүч илэрхийлэгддэг.”

СУРГААЛ БА ГЭРЭЭ 84:20

“Мөн энэ нь—бид Их Эзэний бүх ёслолд алхах болно гэсэн бидний гэрээ байх болно.”

СУРГААЛ БА ГЭРЭЭ 136:4

“Би Их Эзэний надад үзүүлсэн тэр маягаар [усан онгоц] барьсан билээ; иймийн тул энэ нь хүмүүсийнхтэй адил байсангүй. Мөн би, Нифай, байн байн ууланд гарч, мөн би Их Эзэнд дахин дахин залбирсан бөлгөө; иймийн тул Их Эзэн надад агуу зүйлийг үзүүлэв.”

1 НИФАЙ 18:2–3



ХАМГИЙН ЧУХАЛ ЗҮЙЛСЭЭ ХИЙХ НЬ

Хэрэв видео бичлэг байхгүй бол энэ эхийг уншина уу.



ӨГҮҮЛЭГЧ: Нэгэн онгоц 12-р сарын нэг орой Флоридад осолдсон юм. 100 гаруй хүний амь эрсдэв. Энэ нь аюулгүй бүсээс ердөө 20 бээрийн зайд болсон байв.

ЕРӨНХИЙЛӨГЧ УГДОРФ: Ослын дараа, шинжээчид шалтгааныг нь тогтоосон юм. Газардахад хэрэглэгддэг төхөөрөмж нь доошлох үед хэвийн ажиллаж байж. Онгоцны бүх механизм маш сайн ажиллаж байсан аж. Ганцхан юмнаас бусад бүх зүйл ном ёсоороо ажиллаж байжээ. Ердөө ганцхан шатсан гэрлийн шил. Ойролцоогоор хорьхон центийн үнэтэй

жижигхэн гэрлийн шил бөөн хэрэг мандуулж, зуу гаруй хүний амь насыг харамсалтайгаар авч одсон билээ.

Мэдээж тэр ажиллагаагүй болсон гэрлийн шил осол гаргаагүй л дээ. Энэ нь нисэх багийнхан тухайн үед чухал мэт санагдсан зүйл дээр бүх анхаарлаа төвлөрүүлж, хамгийн чухал зүйлийнхээ талаар мартсанаас болжээ.

Хамгийн чухал юмсын оронд өчүүхэн жижиг зүйлст хамаг анхаарлаа төвлөрүүлдэг нь зөвхөн нисгэгчдэд биш, бид бүгдэд тохиолддог. Бид бүгд аюулд учирч болно. . . . Зүрх сэтгэл, бодол санаа чинь тухайн үед чухал мэт санагдах агишин зуурын зүйлүүд дээр төвлөрч байна уу? Эсвэл хамгийн чухал зүйлсийн тухай бодож байна уу?

(Дийтр Ф.Угдорф, “Бид агуу ажил хийж байна. Тиймээс ухарч болохгүй,” Ensign эсвэл 2009 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 69–72)

ХӨРСНИЙ МЕНЕЖМЕНТИЙН ХУУЛЬ

АХЛАГЧ ВИДЦӨҮ: Хэдэн жилийн турш манай ажилтнууд холбооны тэтгэлгээр хөрсний чийгийн салбарт олон мянган мэдээлэл цуглуулсан ч би тэдгээрийг ажиллуулж чадах ямар нэгэн ерөнхий хууль гаргаж чадаагүй юм. Би хамгийн сүүлд бууж өгөв.

Эхнэр бид хоёр тэр өдөр энэхүү бүтэлгүйтлийг мартагын тулд ариун сүм рүү явсан юм. Хувийн хишигийн гурав дахь өрөөнд байж байтал хэвлэлтэнд явснаа-

саа хойш боломжгүй байсан нэгэн шийдэл үл харагдах байдлаар ирсэн юм. . . .

Энэ бол ариун сүмд зохистой ордог хүмүүст ирдэг бэлэг юм. Учир нь энэ бол илчлэлт хүлээн авч болох газар билээ. Энэ нь үнэн болохыг би хувийн гэрчлэлээрээ гэрчилж байна.

(In Alan K. Parrish, Modern Temple Worship, 156)

“Биднийг ариун сүмийн ёслолуудын ариун нандин ажилд оролцоход Их Эзэн адислах болно. Тэрхүү адислалууд нь бидний ариун сүмийн үйлчлэлээр хязгаарлагддаггүй. Бид бүх үйл хэрэгтээ адислагдах болно. Бид сүнслэг болон материаллаг байдалдаа Их Эзэний тусламжийг хүлээн авах эрхтэй болно.”

БОИД К.ПАКЭР, The Holy Temple (1980), 182

ТӨГСГӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Урагш тэмүүл, үйлчил

УРАГШ ТЭМҮҮЛ, ҮЙЛЧИЛ

Тунгаан бод: Баруун гар талд байгаа судрууд болон эшлэлүүдэд хэлснээр бусдад үйлчлэн, өөрсдийгөө *орхих нь* үнэн хэрэгтээ биднийг хэрхэн *авардаг* вэ?

Унш: Та *Миний Суурь* товхимлыг дуусгасан учир бид таныг 7-р зарчим дээрх ерөнхийлөгч Угдорфын хэлсэн зөвлөгөөг дахин бодож үзэхэд урьж байна. Ерөнхийлөгч Угдорф:

“Амь бие хайргүй үйлчилж, бүхнээ зориулах нь бидний сэтгэл санааг ариусган, сүнсний мэлмийг нээж, тэнгэрийн үүдийг дэлгэж өгдөг. Бид хэн нэгний залбирлын хариу болсноороо өөрсдийнхөө залбирлын хариуг авдаг.

Дийтр Ф.Угдорф, “Дамаск орох зам дээр хүлээн сууна,” Ensign эсвэл 2011 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 77

Ярилц: Бусдад үйлчлэх нь та нарын амьдралд хэрхэн “тэнгэрийн цонхнуудыг” нээж чадах вэ?

Дасгал: Бүлгийнхэнтэйгээ эсвэл гэр бүлийнхэнтэйгээ хамт дараах зүйлсийн аль нэгийг хийх төлөвлөгөө гарга:

1. Орон нутагтаа үйлчлэх төсөл хэрэгжүүл. Та нар эмнэлэгт байгаа өвчтэй хүн дээр очиж үйлчлэл хийх, асрамжийн газар хоол хүнс аваачиж өгч эсвэл өөр үйл ажиллагаа сонгож болно.
2. Гэр бүлийнхэнтэйгээ хамт хамгийн ойрхон Сүмийн гэр бүлийн түүхийн төв дээр оч. *Миний гэр бүл: Биднийг нэгтгэдэг түүхүүд* товхимлыг ашиглан гэр бүлийн түүхээ бэлд. Тэгээд ариун сүм рүү явж, нас барсан гэр бүлийнхээ гишүүдийн төлөө ариун нандин ёслолуудыг гүйцэтгэ.
3. Бие даах чадвар хөгжүүлэх төвд сайн дураараа ажилла эсвэл бүлгийн зохицуулагчаар үйлчил. Хэн нэгнийг өөрөө хичээж бие даах чадвартай болох замд нь зааж, зөвлө.



Миний гэр бүл

Биднийг нэгтгэдэг түүхүүд



“Учир нь хэн өөрийнхөө амийг аврахыг хүснэ, тэр хүн түүнийгээ алдана. Харин хэн Миний төлөө өөрийн амийг алдана, тэр хүн түүнийгээ олно.”

МАТАЙ 16:25

“Та нар бусдадаа үйлчилж байгаа нь та нар зөвхөн Бурхандаа үйлчилж байгаа гэдгээ мэдэж болохын тулд буюу.”

МОЗАЯ 2:17

“Материаллаг болон сүнслэг байдлын хувьд бие даах чадварын аль алиных нь зорилго нь хэрэгцээтэй хүмүүсийг өргөн дэмжих чадвартай байхын тулд өөрсдийгөө өндөр түвшинд гаргах явдал юм.”

РОБЭРТ Д.ХЭЙЛС,

“Өөрсдийгөө таньж мэдэх нь: Ариун ёслол, ариун сүм, үйлчлэлийн золиослол” *Ensign* эсвэл 2012 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 35

ТӨГССӨН ТУХАЙ ЗАХИДАЛ

Би, _____ Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн зохион байгуулсан бие даах чадвар хөгжүүлэх бүлэгт хамрагдаж, төгсөхөд тавигдах дараах шаардлагуудыг хангалаа:

Би нийт 12 цугларалт болсны доод тал нь аравт нь оролцсон.

Би нийт 12 зарчмыг давтан үзэж, бүх зарчмыг гэр бүлийнхэндээ заасан.

Би төгсгөл хэсгийн үйл ажиллагааг хийж дуусгасан.

Би бие даах чадвараа хөгжүүлэхэд шаардлагатай ур чадвар, зарчим, дадал хэвшлүүдийн суурийг дадлага хийж, хөгжүүлсэн. Би эдгээрийг амьдралынхаа турш үргэлжлүүлэн хэрэгжүүлэх болно.

Оролцогчийн нэр

Оролцогчийн гарын үсэг

Огноо


Би энэхүү оролцогчийг дээрх шаардлагуудыг хангасныг баталж байна.

Зохицуулагчийн нэр

Зохицуулагчийн гарын үсэг

Огноо

Тайлбар: Гэрчилгээг дараа нь гадас, дүүргийн бие даах чадвар хөгжүүлэх хорооноос олгох болно.



ТА БИЕ ДААХ ЧАДВАР ХӨГЖҮҮЛЭХ ЗАМАА ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ ҮҮ?

“Тиймийн тул, та нар ямархуу маягийн хүмүүс байвал зохих билээ? Үнэнээр би та нарт хэлье, бүр миний адил буюу.”

3 НИФАЙ 27:27

Өдөр бүр
хариуцлагатай
ҮЙЛД

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

